

НОГООН АЛТ, МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД ТӨСЛИЙН НЭГДСЭН ҮЕ ШАТ

БАРИМТ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр:

Ногоон алт, малын эрүүл мэнд
төслийн нэгдсэн үе шат

Хугацаа:

2017-2020

Төсөв:

7.0 сая шв.франк

Зорилтот бүлэг:

- 80,000 малчин өрх
- 100 малчдын хоршоо
- Бэлчээр ашиглагчдын холбоо, малчдын хоршооны 1800 гаруй удирдах ажилтан
- Малчдын дундын сангийн гишүүн 23000 малчин өрх
- 7000 төрийн албан хаагчид болон аймаг, сумын иргэдийн хурлын төлөөлөгчид



Архангай аймгийн Ихтамир сумын Хужир улаалзай БАХ-ийн гишүүн П. Батболдын хотонд мал төллөх цагаар.

ҮНДЭСЛЭЛ

Малын тэжээлийн үндсэн эх үүсвэр болсон бэлчээр нутаг Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 80 хувийг эзэлдэг. Эрдэмтдийн хийсэн судалгааны дүнгээс үзэхэд бэлчээр нутгийн 65 хувийн унаган төрх өөрчлөгдөж доройтолд өртжээ. Энэ нөхцөл байдал Монгол Улсын мал аж ахуйн үйлдвэрлэл,

малчдын амьжиргааны тогтвортой, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Иймд, бэлчээр нутгаа зохистой ашиглах, талхагдлыг бууруулах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бодитой үйл ажиллагаануудыг яаралтай хэрэгжүүлэх цаг тулж ирсэн байна.

ЗОРИЛГО

Бэлчээрийн тогтвортой менежмент, малын гаралтай бүтээгдэхүүний маркетинг, малын эрүүл мэндийг сайжруулах чиглэлээр гарсан үр дүн, амжилтуудыг өргөжүүлэн нэвтрүүлэхэд оршино.

ӨМНӨХ ҮЕ ШАТНЫ ҮР ДҮНГЭЭС:

Экологийн чадавхид суурилсан, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн бэлчээрийн төлөв байдлыг хянах үнэлгээний системийг (схем 1) Засгийн газрын мэргэжлийн байгууллага, агентлагуудтай хамтран нэвтрүүллээ. Энэхүү шинэ аргачлалыг орон нутгийн түвшинд 7 аймагт хэрэгжүүлж байна.

Ногоон алт төслийн дэмжлэгээр малчдын бэлчээр ашиглагчдын 1300 хэсгүүдэд (БАХ) тулгуурласан 35,000 малчин өрхийн гишүүнчлэл бүхий сум, аймгийн Бэлчээр ашиглагчдын холбоодыг нэгтгэсэн Үндэсний бэлчээр ашиглагчдын холбоо байгуулагдлаа.

Бэлчээрийн сэргэх чадавхид суурилсан ашиглалт



Схем 1

ШХА-ийн зорилго:

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн эрх тэгш, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахыг зорино.

Малчид орон нутгийн шийдвэр гаргах үйл явцад илүү идэвх оролцоотой болж, тэдний төлөөлөл болох 97 Бэлчээр ашиглагчдын хэсгийн ахлагч, 217 малчин 2016 онд орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд сонгогдсон байна. Сумын Засаг дарга болон малчдын БАХ-ийн хооронд 700 орчим бэлчээр ашиглалтын гэрээ байгуулагджээ. Малчид БАХ-ийн зохион байгуулалтдаа түшиглэн түүхий эд борлуулах, хадгаламж зээлийн үйлчилгээг үзүүлэх 70 гаруй анхан шатны хоршоодыг байгуулсан байна. Түүнчлэн 19,000 гишүүнтэй, 2.5 тэрбум төгрөгийн хамтын хөрөнгө бүхий 600 гаруй БАХ-ын дундын сан байгуулагдан ажиллаж байна. Анхан болон дундын хоршоодоор

дамжуулан боловсруулах үйлдвэрүүдэд гарал үүслийг нь тодорхойлсон, өндөр чанарын сарлагийн самнасан хөөвөр, тэмээний ноос, мах, арьс, шир нийлүүлж байна.

Малын эрүүл мэндийн төслөөр ШХА нь олон улсын стандартад нийцсэн малын эрүүл мэндийн тухай хууль боловсруулахад ХХААХҮЯ-нд дэмжлэг үзүүллээ. Шүлхий, бруцеллэзын хяналтын шинэ стратеги, шүлхийн хяналтын үндэсний хөтөлбөрийг боловруулснаар өвчлөл гарахад авах арга хэмжээ сайжирлаа. Олон улсын жишигт нийцсэн мал эмнэлгийн албан ёсны боловсролын иж бүрэн хөтөлбөрийг нэвтрүүлж, сургалтын орчинг сайжруулав.



Схем 2

ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН

1. Бэлчээр ашиглагчдын хэсэг (БАХ), бэлчээр ашиглалтын гэрээгээр дамжуулан бэлчээрийн тогтвортой менежментийг төлөвшүүлэх
2. Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулж мал аж ахуйн бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх

3. Малын эрүүл мэндийн үр өгөөжтэй тогтолцоо, бэлчээрийн тогтвортой менежментийн бодлогын таатай орчинг дэмжих

замаар малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх

Зорилтот газар зүйн бүс



Схем 3

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:

- Аймгийн болон Үндэсний бэлчээр ашиглагчдын холбоод
- Малчдын хоршоод
- Хувийн болон төрийн мал эмнэлгийн үйлчилгээний байгууллагууд
- Боловсруулах үйлдвэрүүд

Хамтран хэрэгжүүлэх түншүүд:

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
- Газрын харилцаа геодези зураг зүйн газар
- Цаг уур, орчны шинжилгээний газар
- Мал эмнэлэг үржлийн газар
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

Холбоо барих:

Ногоон алт, малын эрүүл мэнд төслийн зохицуулах нэгж

Скай Плаза Бизнес төв
Элчингийн гудамж 9
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо
Улаанбаатар хот 14220

Ш/Х 37, Улаанбаатар 14210
Монгол улс

Утас: +976 11 326401
Факс: +976 11 326517
И-мэйл: ulaanbaatar@greengold.mn
Вэб хуудас: www.greengold.mn

Монгол дахь Швейцарын ЭСЯ-ны Хамтын ажиллагааны газар

Скай Плаза Бизнес төв
Элчингийн гудамж 9
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
Улаанбаатар хот 14220

Ш/Х 37, Улаанбаатар 14210,
Монгол Улс

Утас: +976 11 331 422
Факс: +976 11 331 420
И-мэйл: ulaanbaatar@eda.admin.ch
Вэб хуудас: www.swiss-cooperation.admin.ch/mongolia